



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 28

Дугаар 14/05

Баян-Өндөр сум

Г

Т

Журам шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1."Аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хугацаа сунгах журам"-ыг нэгдүгээр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх "Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл"-ийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 98 дугаар тогтоол, 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 82 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д. МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023
оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит XIV
хуралдааны 11/12 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ СҮМ, ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛЖ,
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ, ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХУГАЦАА СУНГАХ ЖУРАМ
НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Монгол улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг Орхон аймагт хэрэгжүүлэх, аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд, шашны байгууллага шинээр байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, цуцлах, зөвшөөрлийн хугацааг сунгах болон тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

**ХОЁР.СҮМ, ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХАД
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**

2.1. Сүм, хийд, шашны байгууллага шинээр байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн иргэд аймгийн ИТХ-ын Ажлын албанад дараах бичиг баримтыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн ирүүлнэ.

2.1.1. Тухайн сүм, хийд, шашны байгууллага байгуулах шаардлага, шашны урсгал, үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл, танилцуулга;

2.1.2. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтын шаардлагыг бүрэн хангасан дүрэм;

2.1.3. Сүм, хийд, шашны байгууллага байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, дэлгэрэнгүй тэмдэглэл (Удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирал, ахлагчийг сонгосон тухай);

2.1.4. Сүм, хийд, шашны байгууллагыг үүсгэн байгуулагчид, удирдах зөвлөлийн дарга, тэргүүн, ахлагч, гадаадын зөвлөх, номлогч, гишүүд, дэмжигчдийн бүртгэл мэдээлэл, шашны боловсрол эзэмшсэнийг нотлох баримт бичиг (овог, нэр, нас, хүйс, боловсрол, мэргэжил шашны ямар боловсрол хэзээ, ямар сургалтаар эзэмшсэн тухай, эрхэлсэн ажил, сургууль, гэрийн хаяг, харилцах утас, нас, хүйс ажил, албан тушаал гэх мэт);

2.1.5. Сүм, хийдээс шүтэн бишрэгчид, итгэгчдийн дунд зохиох ажлын гол агуулга, чиглэл, шашны зан үйлийг явуулахад шаардагдах ном, судар бичгийн жагсаалт түүнийг фото зургаар баримтжуулан ирүүлэх;

2.1.6. Сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн байршил, шаардлага хангасан байр, танхимиын талаарх бичиг баримтын хуулбар эсвэл байр танхим тогтвортой ашиглахаар байгуулсан гэрээ; (Баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангасан хэлбэрээр ирүүлэх)

2.1.7. Сүм, хийд, шашны байгууллага байгуулах үйл ажиллагаа явуулах хөрөнгийн эх үүсвэр, үйл ажиллагааны санхүүжилтийн дэлгэрэнгүй тооцоог гаргаж ирүүлэх;

2.1.8. Тухайн сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагаанд гадаадын иргэн оролцох бол тохирсон ангиллын оршин суух визний хуулбар,

тухай иргэний дэлгэрэнгүй мэдээлэл, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх байгууллагын тодорхойлолт;

2.1.9.Хэрэв нийслэл болон өөр нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сүм, хийд, шашны байгууллагын салбар бол төв байгууллагын зөвшөөрөл, хүсэлт;

2.1.10.Шинээр байгууллагдах сүм, хийд, шашны байгууллагын талаар аймгийн Засаг даргаас гаргасан санал, дүгнэлт;

2.1.11.Буддын шашны сүм, хийд, дацан, төв нь Ганданшаддувлэн хийдээс албан ёсны тодорхойлолт авсан байна.

2.2.Сүм, хийд, шашны байгууллага байгуулахыг хүсэж, өргөдөл ирүүлсэн иргэдэд Монгол улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон холбогдох журмыг аймгийн ИТХ-ын Ажлын албанаас танилцуулна.

2.3.Хэрэв дээр дурдсан баримт бичгийн бүрдэл дутуу бол материалыг хүсэлт гаргагчид буцаана.

ГУРАВ.ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СҮНГАХ

3.1.Сүм, хийд, шашны байгууллага нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаа дуусахаас 45-аас доошгүй хоногийн өмнө аймгийн ИТХ-ын Ажлын албан дараах бичиг баримтыг бүрдүүлэн ирүүлсэн байна. Үүнд:

3.1.1.Зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг хүссэн өргөдөл;

3.1.2.Тухайн зөвшөөрлийн хугацаанд сүм, хийд, шашны байгууллагаас явуулсан үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан,

3.1.3.Аймгийн Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт;

3.1.4.Багийн Засаг даргын тодорхойлолт;

3.1.5.Зөвшөөрлийн хугацаа сунгуулах, сүм, хийд, шашны байгууллагын тэргүүн, удирдах зөвлөл, үндсэн болон сайн дурын ажилчдын мэдээлэл, хүүхэд, сүсэгтэн, итгэгч нарын тоо, судалгааг жагсаалтаар гаргаж ирүүлэх.

3.2.Явуулсан үйл ажиллагаа, хийгдсэн ажлууд, шүтэн бишрэгчид, итгэгчдийн тоо болон бусад асуудлыг харгалзан хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

3.3.Хэрэв дээр дурдсан баримт бичгийн бүрдэл дутуу бол материалыг хүсэлт гаргагчид буцаана.

ДӨРӨВ. СҮМ, ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ, ХУГАЦАА СҮНГАХ ТУХАЙ ӨРГӨДЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ШИЙДВЭРЛЭХ

4.1.Аймгийн ИТХ-ын Ажлын албанд ирүүлсэн өргөдөл, бичиг баримтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад урьдчилан танилцуулна.

4.2.Аймгийн ИТХ-ын даргад танилцуулсан сүм, хийд, шашны байгууллага байгуулах, үйл ажиллагааны хугацаа сунгуулахаар ирүүлсэн өргөдөл, баримт, бичгийн бүрдлийг Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон энэхүү журмын 2, 3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан эсэхийг аймгийн ИТХ-ын дэргэдэх “Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл” 30 хоногийн дотор хянан үзэж, санал, дүгнэлтээ аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулна.

4.3.Сүм, хийд, шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох тухай асуудлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.4.Сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгоно.

4.5.Сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгана.

ТАВ.ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

5.1.Сүм, хийд, шашны байгууллага нь дараах үүрэг хүлээнэ.

5.1.1.Сүм, хийд, шашны байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэ журмыг чандлан мөрдөнө.

5.1.2.Тухайн сүм, хийд, шашны байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа нь ард иргэдийн үндэсний ёс заншил, ашиг сонирхолтой нийцэж, амгалан тайван байдлыг хүндэтгэсэн байвал зохино.

5.1.3.Улс орны болон орон нутгийн хэмжээнд гамшиг, ослыг арилгах, хүн ардын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зарлагдсан онц байдал, онцгой дэглэмийн шаардлагыг сүм, хийд, шашны байгууллага нь нэгэн адил биелүүлнэ.

5.1.4.Сүм, хийд, шашны байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажлыг зохион байгуулж ажиллана.

5.1.5.Сүм, хийд, шашны байгууллага нь лам, санваартан, шүтэн бишрэгчдийн тоо, тухайн жилд хийсэн ажлын тайлан, танилцуулгыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ирүүлнэ.

5.1.6.Гадаад улсын шашны байгууллага, гадаад улстай хамтран ажилладаг бол тухайн байгууллагын талаар ерөнхий мэдээлэл, хөрөнгө санхүүгийн тусламж дэмжлэгийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ирүүлнэ.

5.1.7.Зөвшөөрөл авсан сүм, хийд, шашны байгууллага нь өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн, анхны батлагдсан дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан, үйл ажиллагааны урсгал, чиглэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр аймгийн ИТХ-ын Ажлын албан ёсоор мэдэгдэнэ.

5.1.8.Гудамж, талбай, олон нийтийн газар шашны байгууллагын шугамаар үйл ажиллагаа явуулах бол жагсаалт, цуглаан хийх журмын тухай хуулийн дагуу сумын Засаг даргаас зөвшөөрөл авна.

5.2 Сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл:

5.2.1.Шашны байгууллага нь Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох бөгөөд Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, иргэдийн зан, заншил, уламжлалд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулах;

5.2.2.Сүм, хийд, шашны байгууллага, лам, санваартан нь иргэдэд шашны үзэл бодлыг тулгах, эд мөнгөөр татах, насанд хүрээгүй хүүхдийг эцэг,

эхийн хараа хяналтаас гадуур сүм, хийд шашны үйл ажиллагаанд оролцуулах, албадан суулгах;

5.2.3.Төрийн өмчийн сургууль, соёлын байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулах, багш нар өөрийн шүтдэг шашныг хүүхдэд шууд болон шууд бус ямар нэгэн хэлбэрээр сурталчлах;

5.2.4.Сүм, хийд, шашны байгууллага нь дүрмээс гадуур үйл ажиллагаа явуулах, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр иргэдэд шашны зан үйлээс бусад аливаа үйлчилгээ явуулах;

5.2.5.Аймгийн ИТХ-ын байгууллагын зөвшөөрөлгүйгээр аймгийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах;

5.2.6.Зөвшөөрөлд заагдсан нутаг дэвсгэрээс өөр байршилд үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ЗУРГАА.ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

6.1.Зөвшөөрөл авсан сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагаанд аймгийн ИТХ, Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл, холбогдох эрхий бүхий байгууллагууд хяналт тавьж ажиллана.

6.2.Монгол Улсын тусгаар тогтолцоултын үндэсний аюулгүй байдал, иргэдийн зан заншил, үндэсний онцлогт харшилсан аливаа үйл ажиллагаа зохион байгуулсан нь нотлогдвол тухайн шашны байгууллагын үйл ажиллагааг нь зогсоохоор Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөлийг хуралдуулж зохих шийдвэр гаргана. Шаардлагатай тохиолдолд материалыг бүрдүүлэн аймгийн ИТХ-ын Ажлын алба шүүхэд шилжүүлнэ.

6.3.Сүм, хийд аливаа шашны байгууллагын талаар иргэдээс ирүүлсэн санал, гомдол, хүсэлтийг Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

6.4.Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл нь нутаг дэвсгэрийн хэмжээнд шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулахдаа бусад хууль, журмуудаар хориглосон үйл ажиллагаа (хараал хийх, хэтэрхий өндөр үнэлгээ тогтоох, хууран мэхлэх, татвараас зайлсхийх) зэрэг үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэхэд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэнэ.

6.5.Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн жилд 1-ээс доошгүй удаа сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагаанд тусгай удирдамжийн дагуу хяналт, шалгалт явуулна.

6.6.Хяналт, шалгалтыг дараах үндэслэлээр зохион байгуулна. Үүнд:

6.6.1.Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөний дагуу болон гишүүн аль нэг байгууллагын санаачилгаар;

6.6.2.Тухайн сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын дагуу;

6.6.3.Бусад үндэслэлээр.

6.7 Хяналт шалгалтын дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулна.

ДОЛОО. СҮМ, ХИЙД, ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООХ

7.1.Сүм, хийд, шашны байгууллага нь үйл ажиллагаагаа зогсоохоор шийдвэр гаргавал холбогдох баримт бичгийг аймгийн ИТХ-ын Ажлын албанад хүргүүлж, аймгийн ИТХ-аас зохих шийдвэр гаргана.

7.2.Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, бусад хууль тогтоомж, энэхүү журмыг зөрчигдсөн нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд тухайн сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоох тухай аймгийн ИТХ-аас тогтоол гаргана.

7.3.Аймгийн ИТХ-ын байгууллагаас сүм, хийд, шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоосон тухай шийдвэр гармагц Улсын бүртгэл, Татварын болон Цагдаагийн байгууллагад албан ёсоор мэдэгдэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

7.4.Тухайн сүм, хийд, шашны байгууллага үйл ажиллагааг нь зогсоохоор гаргасан шийдвэрийг эс хүлээн зөвшөөрвэл хууль тогтоомжийн дагуу шүүхэд гомдол гаргаж болно.

НАЙМ. ЖУРМЫН ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, БУСАД

8.1.Энэхүү журам нь Орхон аймагт шашны байгууллага явуулж байгаа сүм, хийд, шашны байгууллагад нэгэн адил үйлчилнэ.

8.2 Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжих ба шаардлагатай гэж үзвэл аймгийн ИТХ-ын хуралдаанаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023
оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит XIV
хуралдааны 14/02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**“АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТӨР, СҮМ, ХИЙДИЙН ХАРИЛЦААГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ”-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Орхон аймгийн ИТХ-ын дэргэдэх Төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөл (энэ журамд цаашид “Зөвлөл” гэх) нь Төр, сүм, хийдийн харилцаатай холбоотой Монгол Улсын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аймгийн ИТХ-д зөвлөх үүрэг бүхий орон тооны бус бүтэц байна.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Төр, сүм, хийдийн харилцааны тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, аймгийн нутаг дэвсгэрт төр, шашин сүм, хийдийн харилцааг зохицуулах журам болон энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

ХОЁР.ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга гишүүдээс бүрдэнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын тогтоолоор батална.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнд үйл ажиллагааных нь чиг үүрэгт орсон засаг захиргааны болон бусад байгууллагын холбогдох албан тушаалтнуудыг оруулна.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.4. Зөвлөлийн ээлжит хуралдааныг хагас жил тутам зохион байгуулна. Зөвлөлийн нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Салбар зөвлөлийн ээлжит бус хуралдааныг даргын санаачилгаар, эсхүл зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар хуралдуулж болно.

2.5. Салбар зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг даргын эрх олгосноор Зөвлөлийн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

2.6. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.7. Зөвлөлийн хуралдаанд асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана.

2.8. Шаардлагатай бол Зөвлөлийн хуралдаанд холбогдох байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

2.9. Зөвлөлийн хуралдааны зөвлөмж, дүгнэлтийг аймгийн ИТХ-д танилцуулна.

2.10. Зөвлөл ажлаа жилээр төлөвлөж, төлөвлөгөөний биелэлтийн явцыг хагас, бүтэн жилээр Хурлын зөвлөл болон Хурлын хуралдаанд танилцуулна.

2.11. Салбар зөвлөлийн хуралдаанаас зөвлөмж, мэдэгдэл, дүгнэлт гарах ба хуралдаан даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

2.12. Салбар зөвлөлийн хуралдааныг тэмдэглэл үйлдэн баталгаажуулах бөгөөд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

ГУРАВ.ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

- 3.1.Төрөөс сүм, хийдтэй харилцах харилцааг зохион байгуулж хэрэгжүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх
- 3.2.Зөвлөл нь эрхлэх асуудлын чиглэлээр хяналт шалгалт хийх, холбогдох шашны байгууллагын ажилтай танилцах
- 3.3.Тухайн нутаг дэвсгэрт төр сүм, хийдийн харилцаатай холбоотой ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах
- 3.4.Хуульд заасан бусад

ДӨРӨВ.ЗӨВЛӨЛИЙН ЭРХЛЭХ АЖИЛ

- 4.1.Зөвлөл дараах асуудлыг хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж, мэдэгдэл гаргана.
 - 4.1.1.Аймгийн хэмжээнд сүм, хийдийн холбогдолтой асуудлууд
 - 4.1.2.Иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй холбоотой асуудлууд
 - 4.1.3.Төр, сүм, хийдийн харилцааны тухай Монгол улсын хууль тогтоомж болон Аймгийн нутаг дэвсгэрт, төр, шашин сүм, хийдийн харилцааг зохицуулах журмын хэрэгжилтийн байдал
 - 4.1.4.Аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэгдэх шашин, сүм, хийдтэй холбогдолтой асуудал
 - 4.1.5.Аймгийн хэмжээнд мөрдөгдөж буй журам болон бусад холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргаж хуралдаанд танилцуулах
 - 4.1.6.Аймгийн ИТХ-ын хуралдаанаас өгсөн чиглэл, удирдамж бусад асуудал
 - 4.1.7.Хяналт шалгалтаар явсан ажлын дүн
 - 4.1.8.Хууль тогтоомжид заасан бусад

ТАВ.ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХ

- 5.1.Зөвлөлийн даргын бүрэн эрх
 - 5.1.1.Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хуралдааныг товлох, даргалах
 - 5.1.2.Зөвлөлийн гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих
 - 5.1.3.Зөвлөлийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх
 - 5.1.4.Зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг батлах
 - 5.1.5. Хууль тогтоомжид заасан бусад
- 5.2.Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх
 - 5.2.1.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг санаачлах, хэлэлцүүлэх, Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал өгөх, төлөвлөгөө, тайлантай танилцах, Салбар зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах
 - 5.2.2.Зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хариуцсан салбар, чиглэлийн дагуу хяналт тавих
 - 5.2.3.Зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр хүргүүлж болно.

ЗУРГАА. ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ЧИГ ҮҮРЭГ

6.1.Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулж, зөвлөлийн даргаар батлуулах

6.2.Зөвлөлийн хуралдааны товыг гишүүдэд зарлах, хэлэлцэх асуудал, түүнд холбогдох материалыг тараах, хүргүүлэх,

6.3.Хуралдааны тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн даргад танилцуулж баталгаажуулах, хуралдаанаас гаргах дүгнэлт, зөвлөмж, мэдэгдлийн төслийг боловсруулан батлуулж, холбогдох газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих,

6.4.Зөвлөлийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны тайланг аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулах

6.5.Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик, тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах, танилцуулах

6.6.Зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, Зөвлөлөөс гарах мэдэгдэл, зөвлөмж, дүгнэлтийг албажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах

6.7.Хууль тогтоомж, зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах

6.8.Зөвлөлийн үйл ажиллагааны дотоод бичиг хэргийг зөвлөлийн нарийн бичгийн дарга буюу аймгийн ИТХ-ын Хурлын зөвлөлүүд хариуцсан мэргэжилтэн эрхэлнэ.

6.9.Хууль тогтоомжид заасан бусад.